

## ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

### Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 1 дүгээр хуралдаан 1 дүгээр сарын 09-ний өдөр 72.7 хувийн ирцтэй хуралдаж, 9 асуудал хэлэлцэн 5 тогтоол гаргаж, хуралдааны тэмдэглэлээр 3 үүрэг өгөв. Үүнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн Хуралдаанаар 2020 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Арван зургаадугаар хуралдаанаар 4 асуудал хэлэлцүүлэхээр тогтлоо.

3. “Төв соёл” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийн Засаг даргад тэмдэглэлээр үүрэг өгсөн.

4. “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөр, “Чулуун соёлын өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрүүдийг батлав.

5. Томуу, томуу төст өвчний талаарх мэдээллийг хэлэлцэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэлд даалган үүрэг чиглэл өгсөн.

6. Газрын нэгдмэл сангийн 2019 оны тайланг хэлэлцээд Аймгийн газрын нэгдмэл санг **7404237** га-гаар, үүнээс хөдөө аж ахуйн газар **5549296.614** га, Хот, тосгон, бусад суурины газар **92250.4722** га, Зам шугам сүлжээний газар **45982.052** га, Ойн сангийн газар **573123.23** га, Усан сан бүхий газар **14285** га, Улсын тусгай хэрэгцээний газар **1129299.63** га -гаар тус тус батламжлан тогтоол гаргалаа.

7. Алтанбулаг сумын хатуу хучилттай авто зам барьж буй аж ахуйн нэгжид уг замд зориулж хайраг олборлох зөвшөөрөл, талбайн байршлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, дайрганы борлуулалтын үнэлгээг тогтоон, төлбөрийг сумын төсөвт төвлөрүүлэх, дайрга олборлосон талбайн нөхөн сэргээлтийг журмын дагуу хийлгэхийг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

8. Заамар сумын зарим иргэдийн бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд газар авахуулах хүсэлтийг хэлэлцээд /Заамар сумын “Дэвжих Заамар”, “Өсөх-ирээдүй”, “Газарчин”, “Ивээл” нөхөрлөлүүд/ холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа бол шийдвэрийн төсөл, танилцуулга боловсруулан ИТХ-ын арван зургаадугаар хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид нийцэхгүй байгаа бол түүгээрээ хариу өгөх арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргад уламжиллаа.

9. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ажлыг дүгнэсэн мэдээллийг хэлэлцсэн тогтоол гаргасан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол Улсын Шинэ Үндсэн Хууль батлагдсаны 28 жилийн ойн өдрийг тохиолдуулан “Үндсэн хууль Монголын ард түмний үнэт зүйл мөн” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, Төв аймгаас сонгогдсон Ардын Их Хурлын депутатуудтай “Өнөө цаг” сэдэвт уулзалт ярилцлага, төрийн албан хаагч, иргэдийн дунд “Үндсэн хууль”-ийн талаар танин мэдэхүйн АХА тэмцээн болон улс, аймгийн цолтой бөхчүүдийн “Манлайн баясгалан” бөхийн барилдаануудыг тус тус зохион байгуулж явууллаа.

Монголын Нутгийн Удирдлагын Холбооноос 21 аймгийн 330 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт зориулсан

сургалтад 27 сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг 1 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд хамруулсан.

2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн дагуу хэлмэгдэгч Н.Монцайн хүүхэд иргэн Д.Шийтэр, хэлмэгдэгч Ш.Цэрэн-Очирын хүүхэд иргэн Х.Буянхишиг, хэлмэгдэгч Д.Чимбээн хүүхэд иргэн Ч.Содовцэрэн, хэлмэгдэгч С.Лувсан-Ёндонгийн хүүхэд иргэн Д.Сүхбаатар нарт шүүхээр 80 сая төгрөг; мөн хэлмэгдэгч Ж.Цэрэндондогийн хүүхэд иргэн Ц.Хадбаатар, Хэлмэгдэгч н.Зэвэгийн хүүхэд иргэн З.Долгорсүрэн нарт шүүхээр 40 сая төгрөг тус тус олгохоор шийдвэрлэснийг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын дарга Ц.Энхбат шилжүүлэн өгч, батламжийг гардууллаа.

2019 оны 1 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд Монгол Улсын ЗГХЭГ-аас зохион байгуулсан нэгдсэн сургалтад аймгийн ИТХ-ын дарга Ц.Энхбат, Засаг дарга Ж.Батжаргал нар хамрагдсан.

### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

**Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:** Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан “Батламж”-ийн хэрэгжилт /3 жилийн өссөн дүн/, “Баг-97” төслийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийн явцыг тус тус аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох үүрэг чиглэл авсан.

27 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, нийт 81 удирдах ажилтны “Нэгдсэн сургалт-семинар”-ыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр; “Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” аймгийн 2020 оны урианы жилийн нээлт, Зуунмод сумын Баянхошуу, Нацагдорж багуудын шинэ байрны нээлт, сумдын Засаг дарга нарын “ЗГ-ын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээ”-г аймгийн Засаг дарга батлах ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулж, цаг үеийн болон шаардлагатай мэдээ мэдээллээр төрийн албан хаагчдыг хангалаа.

Дархан-Уул аймгийн ЗДТГ, Орхон сумын ЗДТГ-ын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажилд аймгийн ЗДТГ-ын 4, хэлтэс агентлагийн 6, сумдын 4 ЗДТГ-ын дарга нарыг оролцууллаа.

Байгууллагын ХАБЭАЗ-ийн хурлыг зохион байгуулж, 2020 үйл ажиллагааны төлөвлөгөөг 14 арга хэмжээтэй боловсруулан батлав.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2019 нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн хэлэлцүүлж, 2020 нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэлтэс, агентлагуудад хүргүүлээ. Мөн 2019 оны өргөдөл, гомдлын мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/369 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж чадавхижуулах хөтөлбөр”-ийн 2019 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Цаг үеийн ажлын мэдээ мэдээлэл хүргэх, шаардлагатай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор 27 сумын удирдлага, салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан 2 удаагийн цахим хурлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

2020 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар Монгол улсын төрийн одон медалиар шагнуулахаар орон нутгаас ирүүлсэн 142 иргэний материалыг /Үүнээс ТАХ 25/ аймгийн Засаг даргын зөвлөлийн хэлэлцүүлсэн.

**Төрийн албаны стандартын хүрээнд:** Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу албан хаагчдын тоо бүртгэл, хүний нөөцийн нэгдсэн

судалгаа, ёс зүйн тайлан зэргийг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж ТАЗ-д хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлөөс Ерөнхий шалгалт зохион байгуулахтай холбогдуулан Салбар зөвлөлийн тогтоолоор шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг байгууллаа. Ерөнхий шалгалтын бүртгэл 2020.01.01-01.30-ны өдрүүдэд цахим хэлбэрээр хийгдсэн.

Төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалтын захиалгыг холбогдох баримт бичгийн хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) сайтаар нээлттэй зарлалаа.

#### Сургалтын мэдээлэл:

№	Сургалт зохион байгуулсан хугацаа	Сургалтад хамрагдсан	
		Байгууллага, албан тушаалтан	ТАХ-ийн тоо
1	2020.01.09	Сумдын ЕБС, Цэцэрлэгийн эрхлэгч нарын нэгдсэн сургалтанд Салбар зөвлөлөөс 2020 онд баримтлах чиглэл, хүний нөөцийн системийн бүртгэлийн тухай	54
2	2020.01.10	Сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, МЭҮТ-ийн мэргэжилтэн нарт зориулсан сургалт	41
3	2020.01.13	Мэдээлэл харилцаа, холбооны газартай цахим систем аймгийн хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдон ERP системийн таинлцуулга сургалтанд хамрагдав	3
4	2020.01.22-23	Төрийн албаны Салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, МЕРИТ төсөлтэй хамтран “Багийн хамтын ажиллагаа хүчирхэг баг бүрдүүлэх нь” сэдэв сургалтыг сумын ЗДТГ-ын дарга, Бодлогын хэлтсийн болон зарим агентлагийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт зориулсан гэрчилгээ олгох сургалт	35
5	2019.01.29-30	Сумдын ИТХ. Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгдсэн сургалт Төрийн албаны Салбар зөвлөлөөс 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар нэгдсэн чиглэл өгч ажиллав.	79
<b>НИЙТ ДҮН</b>		<b>8 байгууллага, нэгж</b>	<b>212</b>

#### Гадаад харилцаа:

**Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:** 2020 оны 1 дүгээр сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **6724** иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 1 дүгээр сард аймгийн веб сайтад **21**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **38** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **4-н** дугаарт **13** мэдээ мэдээлэл бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **18** мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор **54** удаа цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **8** гомдол, **2** санал, **1** хүсэлт ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавихад 100%-тай байна. Хугацаа болоогүй 5 гомдол байна.

**Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ:** Геологи, уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчин болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын ахлах байцаагчийн хамтарсан 19-04-002/01 дугаартай зөвлөмжийг 5 ААН-д, сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нараар дамжуулан тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН-дэд тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нарт 01 дүгээр сарын 10-ны өдөр Байгаль орчныг хамгаалах багц хууль, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай тогтоомж болон Мэргэжлийн хяналтын ерөнхий шаардлага, стандартын талаар зөвлөгөө өгөх мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулж, 2020 оны “Хамтран ажиллах хариуцлагын гэрээ”-г байгууллаа.

**Төлөвлөгөөт бус шалгалт:** Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу МХЕГ-ын 01/12 тоот удирдамжийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлсэн өвчтний 2019 оны 12 дугаар сар, 2020 оны 01 дүгээр сарын өвчний 130 гаруй түүхийг судалж, мэдээллийг нэгтгэн МХЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

**Барилгын техникийн хяналт:** МУЗГ-ын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, Төв аймгийн Засаг даргын 2019 оны А/38 тоот захирамжаар Сэргэлэн, Лүн суманд “Батинженеринг” ХХК-аар гүйцэтгэгдсэн “Горгаз” ХХК-ний ШТС барилгын угсралтын ажлын гүйцэтгэлд шалгалт хийж, байнгын ашиглалтад оруулах бүрэлдэхүүнд ажиллав. Дэлхийн зөн Монгол ОУБ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Батсүмбэр сумын Ерөнхий болосвролын сургуулийн Ариун цэврийн байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлд төлөвлөгөөт бус шалгалт хийж, улсын байцаагчийн дүгнэлт боловсруулж, хүргүүллээ.

**Байгаль орчны хяналт:** Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн зөрчлийн хэрэгт Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

**Бусад хяналт:** 3 аж ахуй нэгжийн 10 дээжийг улаанбуудайн тарих үрийн чанарын шинжилгээнд, төмс, хүнсний ногооны 3 дээжинд нитрат, ургамлын өвчин, хортон шавжийн шинжилгээнд тус тус хамруулав.

**Итгэмжлэгдсэн лаборатори:** Хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 72 сорьцыг шалган хүлээн авч 266 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэж, үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олголоо.

**Онцгой байдлын газрын хүрээнд:** Монгол Улсад Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсч хөгжсөний 98 жилийн ойг тохиолдуулан “Онцгой байдлын алба хаагчдын гэр бүлийн зөвлөгөөн”-ийн зохион байгуулав.

Аймгийн онцгой комиссын анхдугаар хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хуралдаж 2 асуудал хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргав. Монгол улс даяар томуу, томуу төст өвчний гаралт ихсэж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 7 хоногийн хугацаатай хөл хорио тогтоов. Энэ хүрээнд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Орон нутгийн өмчийн газар, Боловсрол соёл урлагийн газруудад уг өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэл хийх үүрэг чиглэл өгсөн.

Мөн 01 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Онцгой комиссын шийдвэрийг үндэслэн Аймгийн онцгой комиссын 2 дугаар хуралдаан хурдалдаж Дэлхий нийтээр тархаж буй Шинэ Корона Вирусын халдварын болзошгүй эрсдэлээс

урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллийг комиссын гишүүдэд танилцуулж, хурлын тэмдэглэлийг албажуулан мэргэжлийн албадад хүргэн урьдчилан сэргийлэх зөвлөмж, арга зүйн дэмжлэгийг түгээж байна.

**Объектын гал:** 2020 оны 01 дүгээр сарын 04-нд Заамар сумын төв 4-р багийн 5-р хэсэг 5-5 тоотод оршин суугч иргэн Д.Ууганбаатарын 5 ханатай гэр бүрэн шатаж сумаас нийт 30 иргэн, 2 техниктэй ажиллаж гал түймрийг бүрэн унтраасан.

2020 оны 01 дүгээр сарын 23-нд Эрдэнэ сумын Тамгана баг /сумын төвдөө/ Өвөрхуурайт 6-р гудамжны 80 тоотод оршин суугч иргэн Н.Алтаржавын 4 ханатай гэр бүрэн шатаж сумаас нийт 16 иргэн, 4 техниктэй ажиллаж гал түймрийг бүрэн унтраасан.

2020 оны 01 дүгээр сарын 03-нд Баянчандмань сумын Эрдэнэ баг /сумын төвөөс зүүн урд зүгт 18 км-т/ малчин Н.Сүрэнхорлоогийн 300 боодол шатаж, сумаас нийт 8 иргэн, 2 техниктэй ажиллаж гал түймрийг бүрэн унтраасан.

### **Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэх арга хэмжээг аймгийн ИТХ-тай хамтран Үндсэн хууль баталсан ИТХ-ын депутатуудтай уулзалт, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар лекц сургалт, иргэдийн дунд АХА тэмцээн, эссэ бичлэгийн уралдаан, төрийн байгууллагуудад шагайн наадгай, спортын тэмцээн, Үндэсний бөхийн барилдаан зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Сумд8 байгууллага бүрт “Үндсэн хуулийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр Үндсэн хуулийг сурталчлах хэлэлцүүлэг сургалт, тэмцээн уралдааныг зохион байгуулж 3480 хүнийг хамрууллаа.

“Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 252 албан тушаалтны нэрсийн жагсаалтыг гаргаж Авлигатай тэмцэх газар хүргүүлэн, мэдүүлэг гаргалтад арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаж байна.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 01 сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 43 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянан зөвлөмж өгч; хууль, эрх зүйн асуудлаар нийт 108 иргэн, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 28 мэдээлэл танилцуулан ажилласан.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхэд Засаг даргыг төлөөлж 2 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцон тайлбар дүгнэлт гаргаж, шүүх хуралдаанд оролцов.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2019 оны 4/666 тоот “Зөвлөмж”-ийн хүрээнд Үндэсний аюулгүй байдал Төв аймагт хэрхэн хангагдаж байгаа тухай Засаг даргын илтгэл, мэдээлэл, 2 зөвлөмж, 1 журмын хэрэгжилт, “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2019 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн ҮАБЗ-ийн ажлын албанд хүргүүллээ. Мөн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон аймгийн Засаг даргын харьяа 27 байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ҮАБ-ыг хангахтай холбоотой 5 арга хэмжээ, сумдын Засаг даргын гэрээнд 2 арга хэмжээ тусгуулан батлуулсан.

**Архивын үйлчилгээ:** Төрийн архивын тасаг, Боловсрол соёл урлагийн газартай хамтран 27 сургууль, цэцэрлэгийн 60 архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад “Архив, албан хэрэг хөтлөлтөд анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулав. Шинээр томилогдсон 7 архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтныг чадавхжуулах дадлага, сургууль хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн архивын эх баримтаас 317 иргэний хүсэлтээр 346 хөмрөгийн 1239 хадгаламжийн нэгж ашиглан 826 хуулбар хувь, 178 лавлагааг гарган үйлчилж, 3.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвд оруулав.

3 хөмрөгийн 364 хадгаламжийн нэгжийн 5626 хуудас баримтын 18106 хүний нэр, 4391 заалтын тоо, 4391 тушаалыг программд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердан өгөгдлийн сантай холбож, цахим бааз үүсгэн эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажил хийлээ.

**Улсын бүртгэлийн хэлтэс: 1. Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:** 2020 оны 01 дүгээр сарын байдлаар цахим санд нийт 53707 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9858, Газар өмчлөх эрхийн 43849 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 14051.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос үл хөдлөх худалдан борлуулсны 14.2 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 396031 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

**2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:** Тайлант сард нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 18 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 13 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Тэмдэгтийн хураамжийн орлого 990.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

**Цагдаагийн байгууллагын мэдээлэл:** Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 82 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хэргээр буюу 9.3 хувиар өссөн, хөнгөн гэмт хэрэг 67 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 9.8 хувиар, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 74 бүртгэгдэж 18 нэгжээр буюу 32.1 хувиар өссөн, мөрдөн байцаалтын гэмт хэрэг 12 бүртгэгдэж 7 нэгжээр буюу 36.8 хувиар буурсан, хүнд гэмт хэрэг 15 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 1 нэгжээр буюу 7.1 хувиар тус тус өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 16.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өссөн.

**Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:** Эрүүлжүүлэх, саатуулах байранд эрүүлжүүлэгдсэн-29, баривчлагдсан-26, саатуулагдсан-6, нийт 61 хүнийг хүлээн авч ар гэр, асран хамгаалагчид 7 хүнийг хүлээлгэн өгөв.

**Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Олон нийтийг хамарсан 8 удаагийн 45 цаг үргэлжилсэн арга хэмжээний хамгаалалтад 15 алба хаагч, 4 тээврийн хэрэгсэл, 30 тусгай хэрэгсэл, 4 станцтай 675 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 1500 орчим иргэний аюулгүй байдлыг ханган ажилласан.

**Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 46 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасч, Зөрчлийн тухай хуулийн 14.7.5-д заасан зөрчлөөр 11 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4223 жолоочийг 127.6 сая төгрөгөөр торгосон.

**Шүүхийн шинжилгээний чиглэлээр:** Криминалистикийн шинжилгээ-20, Магадлан шинжилгээ-18, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-74, гарын мөрийн санг баяжуулсан-28, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 73 гаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:**

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
01 дүгээр сар	321	59	-	380	61	319	16%
	4335533.1	152679.9	-	4488213.0	165803.0	4388410.0	

**Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд**

**Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ:** Аймгийн хэмжээнд 2020 онд **68181.4 сая** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэнэ. Үүнд:

- УХО-аар 53690.3 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ
- ОНХС-аар 4510.0 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 4866.7 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 611.0 сая төгрөгийн 10 арга хэмжээ
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 743.1 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ
- 27 суманд 3760.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тусгагдлаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.Khural.mn](http://www.Khural.mn) сайт, “Өдрийн сонин”-ны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар-003 (6369)-т, “Монголын үнэн” сонины 01 дүгээр сарын 08-ны өдрийн Дугаар-003-т тус тус нийтлүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангалаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 71 төсөл, арга хэмжээнд 9900.8 сая төгрөгийн санхүүжилт баталснаас, тендер шалгаруулалтаар зохион байгуулж хэрэгжүүлэх 50 төсөл, арга хэмжээг 7885.3 сая төгрөгийн санхүүжилтээр батлагдаж, дараах хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалт эхлүүлээ. Үүнд:

1. Баян-Өнжүүл сумын Эрүүл мэндийн төвийн барилга барих /10 ортой/
2. Орон нутгийн хөгжлийн сангаас 26 суманд бэлчээрийн худаг гаргах, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангаас 13 суманд бэлчээрийн худаг гаргах /Алтанбулаг, Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант, Баян, Баянцагаан, Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Сэргэлэн, Лүн, Өндөрширээт, Баян-Өнжүүл сум/ тендер
3. Хот тохижуулах газрын хогны машин шинэчлэх тендер
4. Орон нутгийн чанартай авто замуудыг тэмдэгжүүлэх, Зуунмод сумын авто замын өвөл, зуны арчлалтын ажил, Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын өдөр тутмын арчлалтын ажлын тендерүүд

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан нэвтрүүлэх ажлыг Зуунмод сумаас эхлүүлэн, 400 барилга байгууламжийн мэдээллийг бүртгэж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй нийтийн халуун ус, инженерийн шугам сүлжээ, Сууц өмчлөгчдийн холбооны судалгааг шинэчлэв.

Сэргэлэн сумын Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудлын Иргэний нисэхийн ерөнхий газрын агаарын хөлгийн засвар үйлчилгээний төв, оффиссын барилга, харуулын байрны барилга, цахилгааны дэд өртөө, өргөх насосны станцын угсралтын ажил, Аргалант сум Хөшөөт 2-р багийн Галзуу хар сууринд Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-ны “Хөдөө аж ахуйн ложистикийн төв”-ийн оффис, махны агуулахын барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөлийг тус тус олголоо.

Архитектур төлөвлөлтийн 10 даалгавар боловсруулан баталлаа. Үүнд:

- Зэвсэгт хүчний 311 дүгээр цэргийн ангийн сургалтын төвийн 36.0x7.8м хэмжээтэй 60 ортой амралтын байрны барилга
- Бүрэн сумын Нутгийн удирдлагын ордны барилга
- Зуунмод сумын Номт баг Тээвэрчдийн гудамж, Соёл хотхонд иргэн Б.Хүрэлбаатарын 54 айлын орон сууцны барилга
- Алтанбулаг сумын 2-р багт /Бөхөгт/ иргэн Тэрбишийн Анхцэцэгийн Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, спорт комплекс, амины орон сууцны хотхоны цогцолбор
- Баянцагаан сумын 2-р баг /Тэвш нуурт/ “Тэвш нуур шохой”ХХК-ны шохой боловсруулах үйлдвэр, уурхайн ажилчдын амрах цогцолбор барилга
- Мөнгөнморьт сумын Булаг 3-р багт /Хэрлэнд/ иргэн П.Энхболдын амралт сувилалын газрын амралтын байрны барилга
- Эрдэнэсант сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Өндөрширээт сумын 10 ортой эрүүл мэндийн барилга
- Баянчандмань сумын Соёлын төвийн барилга 30.0x18.5м
- Борнуур суманд “Горгаз”ХХК-ний олон төрөлт шатахуун түгээх станц барилга

Барилгын эх загвар, ажлын 3 зураг төслийг хянав. Үүнд:

- Мөнгөнморьт сумын Булаг 3-р багт /Хэрлэн/ иргэн П.Энхболдын амралт сувилалын газрын байрны барилга
- Баянцагаан сумын 2-р баг /Тэвш нуур/ “Тэвш нуур шохой” ХХК-ны шохой боловсруулах үйлдвэр, уурхайн ажилчдын амрах цогцолбор барилга
- Улаанбаатар хотын СХД-ийн 32-р хороо, “Эмээлт” дэд станцаас 10кВ-ын Төмөр зам фидерийн Хүй 7 худаг салбарын 101-р тулгуурт 10 кв-ын ЦДАШ-ын холбох ажил

**ХАА-н чиглэлээр:** Улс, аймгийн аварга шалгаруулах тодорхойлолтыг хүлээн авч, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагад хүргүүллээ.

***Газар тариалангийн хүрээнд:*** Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “МОНГОЛ ТҮМНИЙ МЭНД” нэвтрүүлэгт Аргалант, Баянцогт, Борнуур Жаргалант сумын үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын үйлдвэрлэл эрхлэгч 4 аж ахуйн нэгж, иргэн оролцлоо.

***Мал аж ахуйн хүрээнд:*** Сумдын Засаг дарга нарт өвөлжилтийн байдал, малын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сэрэмжүүлэг 2 удаа хүргүүлэн хяналт тавьж байна. Зуншлага тааруу байсан, эрсдэлтэй бүс нутгийн тал хээрийн 13 сумын малчдад болзошгүй эрсдэлээс сэргийлэн 210 тн өвсийг үнэгүй, 95 тн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр тус тус олгох ажлыг зохион байгуулав.

Арьс ширний урамшуулалд хамрагдах 2019 оны материал хүлээн авч, баримтыг нягтлан бүртгэжүүлэв.

***Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:*** Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, аймгийн ХАҮТанхимтай хамтран 10 сумын 40 гаруй үйлдвэрлэл,



үйлчилгээ, худалдааны төлөөллийг оролцуулан “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлэг” зохион байгуулж, аймгийн салбар хороог байгууллаа.

“Бизнесээ эхэл” төсөл боловсруулах сургалтыг Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-тай хамтран Жаргалант суманд зохион байгуулж, 16 жижиг дунд бизнес эрхлэгчийг хамруулав. Баянчандмань суманд *Сүүндалай оргил* хоршоо өдөрт 1000 л сүү боловсруулах хүчин чадалтай боловсруулах үйлдвэр ашиглалтад орлоо.

Аймгийн хэмжээнд 2019-2020 онд хүнсэнд хэрэглэх, зах зээлд 1.3 сая толгой мал буюу 39.5 мян.тн мах бэлтгэж; 3 махны үйлдвэр, 8 мал төхөөрөх цехд 32700 тн мах үйлдвэрийн аргаар бэлтгэж, төв суурингийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан 60.3 тн мах нөөцөлж бэлтгэсэн.

ЖДҮХС-аас зээлд хамрагдсан 9 төсөл хэрэгжүүлэгчийн зээлийн зарцуулалт, явцад хяналт үнэлгээ хийж ХХААХҮЯ-нд тайлагналаа. СХС-ийн эх үүсвэрээс 2019 онд 298 төсөлд 2265.8 сая төгрөгийн зээл олгосон мэдээллийг *Бүртгэл, хяналтын нэгдсэн цахим программд* бүртгэж тайлагналаа.

**Мал эмнэлгийн үйлчилгээ:** Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэгт 750.0 мян төгрөгийн цахим гэрчилгээг шалгах төхөөрөмж олгов. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2103,6 мян/мал хамруулахаар төлөвлөн вакцины нийлүүлэлт 0.5% байна. Мал эмнэлгийн нэгдсэн системийг 01 дүгээр сарын 01-ээс эхлэн нэвтрүүлж 2479 гэрчилгээ олгосон.

Батсүмбэр, Сэргэлэн, Зуунмод сумын мал бүхий иргэдийн үнээ, Эрдэнэ сумын Жигд хүч ХХК-ний үнээний фермийн аж ахуйн 80 толгой үнээг бруцеллёзын шинжилгээ, 5 сумын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа махны дээжинд антибиотекийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээ 30 удаа, Баянжаргалан, Баяндэлгэр, Цээл, Эрдэнэсант, Зуунмод сумдаас ирүүлсэн сүүний дээжинд 8 удаа, эрүүл ахуй, бруцеллёзын шинжилгээ 4 сумын 10 толгой адуунд адууны нийлүүлгийн өвчний шинжилгээ тус тус хийлээ.

**Газрын харилцааны үйлчилгээ:** Газрын нэгдмэл сангийн 2019 оны тайланг аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлээ. Тус тайлангаар аймгийн кадастрын мэдээллийн сангийн бүртгэлтэй 58313 үндсэн нэгж талбар бүртгэлтэй байсан бол 2020 оны 01 дүгээр сарын 28-ны байдлаар 63048 үндсэн нэгж талбар, 18602 ажлын нэгж талбар бүртгэгдэж үндсэн нэгж талбар 4735-аар нэмэгдлээ.

“Газрын биржийн цахим систем”-д 2019 онд зохион байгуулагдсан дуудлага худалдаа 283, төсөл сонгон шалгаруулалтын 4 мэдээг нэгтгэн бүртгэн баталгаажуулав.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр аймгийн хэмжээнд хот суурин газар 11541 нэгж талбарт 9862.79 га газар өмчлүүлж, эзэмшүүлж ашиглуулах, хөдөө аж ахуйн салбарт 1699 нэгж талбарт 364145.68 га газар эзэмшүүлэх, хамгаалах, сайжруулах арга хэмжээ, газрын дуудлага худалдаагаар 267 байршилд 2550,4 га газар эзэмшүүлэхээр төлөвлөлөө.

**Байгаль орчны чиглэлээр:** Баян сумын нутагт үйл ажиллагаа эрхэлж буй Цэцэнс майнинг энд энержи ХХК-ний уурхайн шүүрлийн усыг газрын гадарга руу гарган хаяж байгаагаас шалтгаалан түвшин нь буурсан гомдлын дагуу ажиллаж, дүгнэлт гаргав. Ан амьтан хамгаалах зүй зохистой ашиглах ажлын хүрээнд агнуурын 6 сумын 10 бүс нутгийн хариуцагч, хамтран ажилладаг зөвлөх байгууллагын 20 төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монгол туургатан театрын уран бүтээлчид, Музей, Дашчойнхорлон хийдтэй хамтран *Шинэ оны анхны нар харах* аялалыг зохион байгуулахад 35 иргэн оролцлоо.

Канадын улсын Мерит төсөлтэй хамтран “Төв аймгийн уул уурхайн салбарын ил тод байдал” цахим сан төслийг хэрэгжүүлэн хариуцлагатай уул уурхайн [www.minig.to.gov.mn](http://www.minig.to.gov.mn) сайт шинээр үүсгэн, ашиглалтыг эхлүүлээ. Тус сайтын цахим мэдээллийн санд аж ахуйн нэгжийн лицензийн мэдээлэл, татвар төлөлтийн байдал, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, эрдэс баялагийн холбоотой мэдээлэл, орон нутгийн хамтын гэрээнүүдийг байршуулан хөгжүүлж байна.

**Орон нутгийн өмчийн чиглэлээр:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын дагуу аймгийн Цагдаагийн газрын хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг судлан 214.1 сая төгрөгийн 254 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, шинэчилсэн үнийг зөвшөөрч шийдвэрлүүлээ.

“Зуунмод мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГазрын “Удирдлагын гэрээ”-г дүгнэх, санхүүгийн баримтын шалгалт, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд 119.161.800 төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт хийгдсэн ажлыг шалгах, баталгаажуулах ажлыг эхлүүлээ.

“Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-аар түрээсийн орон сууцанд хамрагдсан 12 өрхийн 1 дүгээр сарын түрээсийн төлбөр 1.2 сая төгрөг хуваарийн дагуу төвлөрүүлэв.

**Стандарт хэмжил зүйн үйлчилгээ:** Худалдаа үйлчилгээ эрхлэх тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгуулах хүсэлт ирүүлсэн Зуунмод, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань сумын 24 иргэн, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээгд тохирлын үнэлгээ хийж, Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр 22 үйлчилгээ, бүтээгдэхүүнд *Тохирлын гэрчилгээ* 1-2 жилийн хугацаагаар олголоо.

Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Таван толгой түлш Дундын бүсийн нүүрсний нөөцийн 100т автомашин жингийн засвар тохируулга, Зуунмод сумын Аксион ХХК-ний эмчилгээ, оношилгооны массын хэмжих хэрэгсэл, Зуунмод сумын худалдаа, үйлчилгээний 23 цэгийн кассын машин, жинг стандартын дагуу шалгаж баталгаажууллаа. Мөн Эрдэнэсант, Лүн, Баянхангай сумын ШТС-ын хэмжих хэрэгслүүдэд баталгаажуулалт хийв.

### **Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Төв соёл” хөтөлбөрийн хэрэгжилт, “Соёлын биет бус өвийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөр, “Чулуун соёлын өвийг” хамгаалах дэд хөтөлбөрийг тус тус хэлэлцүүлэн батлууллаа. 2019 онд нийгмийн салбарт хийсэн онцлох ажил, үр дүнг иргэд олон нийтэд мэдээлэх зорилгоор “Төв times” сонинд эхийг бэлтгэн хэвлүүлэв.

МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Эрдэнэ МСҮТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, мах боловсруулах үйлдвэр, тогооч, сүү боловсруулах ажилтны ангиудаар орж, сургалтыг үйлдвэрлэлтэй холбож байгаа сайн жишээг онцоллоо. Мөн энэ үеэр аймгийн удирдлагууд Эрдэнэ сумын иргэдтэй уулзалт зохион байгуулж, шинэ баригдсан цэцэрлэг, Номин халамжийн цэцэрлэг, ЭМТ-ийн үйл ажиллагаатай танилцан тулгамдаж буй зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэсэн.

Төв Аймгийн Засаг дарга, МУБИС-ийн захиралтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу МУБИС-ийн МБУС-ийн дэргэдэх "Моноцүкүри" төслөөс 2

дах удаагаа ерөнхий боловсролын 11 сургуульд физикийн “Цахилгаан соронзон бүлэг”-ийн 34.0 сая төгрөгийн үнэ бүхий 40 цогц багажийг гардуулан өгч, багш нарт “Цахилгаан соронзны цогц багажийг ашиглах” сургалт зохион байгуулав.

27 сумын 43 цэцэрлэгийн эрхлэгч, 29 захиралын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, нэгдсэн үнэлгээ, санал, зөвлөмжийг хүргүүлж, “Боловсролын салбарт анхаарах асуудал, туршлага, сургамж” сэдэвт 1 өдрийн сургалтыг явуулж, УБ хотын улсын тэргүүний 84 дүгээр сургууль, 112 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлах ажлыг зохион байгууллаа.

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч, гэрийн эргэлтийг нэмэгдүүлэх, яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор 27 суманд тус бүр 500 мянган төгрөгийн шатахуун, 26 сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн ЭМТ-д алсаас халуун хэмжигч, сум бүрт 4ш пульсоксиметр зэрэг 27.488.0 төгрөгийн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжөөр хангалаа.

**Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ:** Тусгай зориулалтын шилжүүлгийн сургуулийн өмнөх боловсролын 44 цэцэрлэгийн 14395.9 сая төгрөг, ерөнхий боловсролын 31 сургуулийн 28140.6 сая төгрөгийн төсвийн хуваарь хийж хүргүүлэв. Орон нутагт ажилласны тэтгэмжийг цэцэрлэгийн 7 албан хаагчид 29.8 сая төгрөг, сургуулийн 36 албан хаагчид 149.6 сая төгрөг, нийт 179.4 сая төгрөгийн санхүүжилт хийлээ.

“Төв” ТВ-тэй хамтран сурагчдын амралт, хөл хорио тогтоосон үед 9 хичээл судлагдахуунаар 16 багш “Багш зөвлөж байна” цуврал зөвлөгөө, зөвлөмж өгөв.

ЕБС, цэцэрлэгийн багш удирдах ажилтан нарт хөл хорио тогтоосонтой холбогдуулан 23 сумын 37 эрхлэгч, 9 арга зүйч, 150 багш, 154 туслах багш, 196 үйлчилгээний ажилтнууд, 30 сургуулийн 30 захирал, давхардсан тоогоор 121 сургалтын менежер, 12 нийгмийн ажилтан нийт 896 албан хаагчдыг хамруулан цахимаар чиглэл зөвлөмж өгөх ажлыг зохион байгууллаа.

Баянцогт, Цээл, Баянхангай сумын 48 ажиллагсдад “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид байлгах орчинг дэмжих нь” орон нутгийн сургалтыг зохион байгуулсан. Мөн Эрдэнэ суманд багш, сурагчдын хандлага төлөвшилд суурилсан “Багш” вакум сургалтыг зохион байгуулахад 12 багш, 36 сурагч хамрагдлаа.

**Монгол туургатан театрын үйлчилгээ:** 4 төрлийн 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулан 270 иргэнд үйлчиллээ. Монгол улсад шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 28 жилийн ойн хүрээнд Ардын их хурлын депутатуудтай хийх уулзалтыг зохион байгуулсан.

**Музейн үйлчилгээ:** МУЗГ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор Улсын хамгаалалтад байх “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаал”-д Баянцагаан сумын “Чихэртийн зоо хүннүгийн оршуулга”, Мөнгөнморьт сумын “Сарьдагийн хийдийн туурь” дурсгалт газруудыг шинээр бүртгүүллээ.

**Нийтийн номын сангийн үйлчилгээ:** 230-н байнгын уншигч, 790 ирэгсэд, нийт 1020 уншигчдад 2910 ном олгож уншууллаа. Шинэ номын үзэсгэлэнг “Үндсэн хуулийн өдөр”-ийг тохиолдуулан уншлагын танхимд гаргасан.

**Биеийн тамир, спортын үйлчилгээ:** Аймгийн БТСГ-ын албан хаагчид Монголын үндэсний олимпийн хорооны үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа.

Аймгийн чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид Жаргалант суманд 14 хоногийн хамтарсан бэлтгэл цугларалтад гараад байна.

**Зохион байгуулсан уралдаан тэмцээн:**

1. Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг МУ-ын спортын мастер Б.Содномдаржаагийн нэрэмжит болгон Лүн суманд зохион байгуулж 41 тамирчин 3 насны ангиллаар, Цанын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Хангайтын цанын баазад зохион явуулж 28 тамирчин тус тус оролцов.

2. ББТА, АБТА, ахмад багш Ц.Гомбын нэрэмжит баруун бүсийн өсвөрийн тамирчдын аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн Лүн суманд зохион байгуулагдаж 8 сумын 100 гаруй өсвөрийн бөхчүүд 10 жинд өрсөлдлөө.

3. Монгол улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойд зориулсан “Манлайн баясгалант” үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулсан.

4. Зуунмодны хүчтэн 2020 тэмцээнийг зохион явуулж 56 тамирчин эр, 4 жин, эм 3 жинд өрсөлдсөн.

**Оролцсон уралдаан тэмцээн:** Хэвтээ шахалтын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 10 мөнгө, 8 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 2-р байрт шалгарлаа.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ:** Батсүмбэр суманд ГБХЗХГ-аас аймгийн Цагдаагийн газартай хамтран 2020.01.23-24-ний өдрүүдэд “Хүүхэд хамгааллын бодлого, чиглэл”, “Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”, боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сургалт зохион байгуулагдлаа. Энэхүү ажлын хүрээнд 10-12 дугаар ангийн 65 сурагч, 89 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 108 багш, сургуулийн ажилтнуудад бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө өгч нийт 262 хүн хамруулан ажиллалаа.

ХНХЯ-ны захиалгаар Хүүхдийн эрхийн форум ТББ-аас Монгол улсын “Хүүхдийн эрхийн тухай хууль”-ийн хэрэгжилтэд “Үр дагаврын үнэлгээ” хийхэд аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, Зуунмод сумын “Хамтарсан баг”, Боловсрол соёл, урлагийн газар, сургуулийн нийгмийн ажилтнууд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газрын холбогдох албан тушаалтнууд болон УИХ-д суудалтай намуудын төлөөлөлтэй уулзаж, судалгаа хийгдсэн.

Аймгийн шатрын аварга шалгаруулах “Цодгор хүү- 2020” тэмцээнийг 01 дүгээр сарын 20-ны өдөр 5 нас, 7 нас, 9 нас, 11 насны ангиллаар Зуунмод суманд зохион байгуулахад 19 сумын 22 багийн 118 шатарчин 24 багц медалийн төлөө өрсөлдөж, тэргүүн байр эзэлсэн 8 тамирчин улсын аварга шалгаруулах “Цодгор хүү- 2020” тэмцээнд оролцох эрхээ авлаа.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ:** 2020 оны 1-р сарын байдлаар 1746 иргэнд 312.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1085 иргэнд 91.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 273 иргэнд 43.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 64 ахмад настанд 16.3 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 60 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 3.5 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж 312 өрхөд 20.4 сая төгрөг, жирэмсэн 808 эхэд 29.2 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 59 ахмад настанд 9.8 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4413 эхэд 220.6 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

Шинэ төрсөн 272 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв. ӨМНСанд бүртгэлтэй 18508 өрхийн 30591 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж, 611.820.000 төгрөгийг зарцуулсан.

“Холт” ОУБ-ын “Хүүхдийн амьжиргааг дэмжих төсөл” хөтөлбөрт хамрагдаж байгаа 40 өрхийн 50 хүүхдийн эцэг эхчүүдэд өрхийн санхүүгийн боловсрол эзэмшүүлж, дундын хадгаламжийн сантай болгох зорилгоор “Бүлэг гэж юу вэ”,

“Бүлгийн ач холбогдол” сэдэлжүүлсэн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 18 эцэг эх хамрагдаж, 17 гишүүнтэй дундын хадгаламжийн бүлэг байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 28 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 11 ажил олгогч байгууллага, иргэний 60 сул чөлөөтэй ажлын байр, 9-н ажилд зуучлагдсан иргэн, 38 шинэ ажлын байрны мэдээллийг санд оруулсан. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 24 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг НДХ-т гаргаж өгөв. Түр ажлын байранд ажилласан 17 иргэний мэдээллийг авсан.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг Зуунмод сумын 72 ААН-ээс авч нэгтгэн ажиллаж байна.

Олон улсын нисэх онгоцны буудлын цэвэрлэгээний ажлын гүйцэтгэгчээр шалгарсан UNISERVES ХХК-тай хамтран гадаад болон дотоод цэвэрлэгээний ажлын байранд ажиллах хүсэлт ирүүлсэн 45 иргэнтэй ярилцлага хийж, тэнцсэн 9 иргэнийг ажилд томилуулахаар болсон.

“Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийн сургагч багшаар дамжуулан Зуунмод, Эрдэнэсант, Эрдэнэ, Баянчандмань сумын 22 бизнес эрхлэгчид 2 өдрийн сургалт зохион байгууллаа.

ХЭДС-ийн 2018 оны зээлээс ХААН банкинд 200,0 сая төгрөгийн эргэн төлөлт, хүүгийн орлого орж ирсэнийг Жижиг зээл олгох төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн Зуунмод сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгч 1 ААН, 8 иргэнд 90,0 сая төгрөгийн зээл олгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэв.

**Нийгмийн даатгалын үйлчилгээ:** Аймгийн хэмжээнд 14039 тэтгэвэр авагчдад 4.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олголоо. ЭХМК-ын 3 удаа хуралдаж, 138 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 28 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 142 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 11 иргэнийг цуцалсан байна.

НДШ-ийн хуримтлагдсан өртэй, 121-ээс дээш хоногийн насжилттай НДШ-ийн өр авлага барагдуулах ажлыг зохион байгуулан Баянчандмань сумын “Агровольфрам” ХХК-ний 13,7 сая төгрөг, Зуунмод сумын “Буянт гол” ХХК-ний 5,6 сая төгрөгийн өртэй 2 ажил олгогчийг шүүхийн байгууллагад шилжүүлэв. Одоогоор Баянчандмань сумын “Агровольфрам” ХХК 10,0 сая төгрөг буюу өрийн 72.9%-ийг барагдуулаад байна.

Засгийн газрын 2019 оны 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах журам”, “1990 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталсан БНМАУ-ын тэтгэврийн хуульд заасан болзол, нөхцөлөөр 1991-1994 онуудад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон” тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг шалгах ажлын хүрээнд 2100 тэтгэврийн хувийн хэргийг шалгаж, болзол нөхцөл хангаж хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 1451 тэтгэвэр авагчдад 50000 төгрөгийн нэмэгдлийг хугацаанд нь хийж, 2020 оны 01 дүгээр сарын тэтгэврийг 72,550,000 төгрөгөөр нэмэгдүүлэн олголоо.

“Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх” тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын баримт бичгийг татаж, нягтлан шалгах ажил хийж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн.

**Эрүүл мэндийн үйлчилгээ:** Жирэмсний хяналтын чанарыг үнэлэх “Гэр үнэлгээний аргачлал” сэдэвт тайлангийн хурал зохион байгуулж, нийт 60 хүн хамрагдлаа. Хурлаар 27 сумын Эрүүл мэндийн төвд хэрэгжүүлсэн жирэмсний хяналтын чанарын үр дүнг тооцож, 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

чиглэлийг тодорхойлов. Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвд “Жирэмсний хяналтын чанарыг үнэлэх” удирдамжийн дагуу 9 эхийн жирэмсний хяналтын картад үнэлгээ хийж, эмч, эмнэлгийн ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Савны гадуурх жирэмсэн эхийг газар дээр нь оношилж, тусламж үйлчилгээ үзүүлэн, нарийн мэргэжлийн эмчид шилжүүлээд байна.

Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч, эх барих эмэгтэйчүүдийн их эмчтэй хамтран “Хүүхдэд зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээ”, “Жирэмсний хяналтын чанарыг үнэлэх нь” сэдэвт бүсчилсэн ажлын байрны сургалтыг Эрдэнэсант, Жаргалант суманд зохион байгуулж, 9 сумын нийт 40 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулсан.

2020 оны эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн захиалгыг 26 сум болон АНЭ-ээс авч аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн, 01 дүгээр сарын 15-ны өдөр тендерийг зарлав.

Магадлан итгэмжлэлд хамрагдах АНЭ, Баян, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Баянцогт, Аксион эмнэлэг, Арга билэг сувиллын материалыг хянаж, ЭМХТөвд хүргүүлсэн.

Гематологи, биохими, шээсний анализатор дээр ажиллах ур чадварын сургалтыг өрх, сумын эрүүл мэндийн төвийн 14 лаборант, 11 мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан.

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 7 сургууль, 3 дотуур байрны нийт 8500 мкв, 10 цэцэрлэгийн 9560 мкв талбайд ариутгал хийлээ. АНЭ, ЭМГ, ӨЭМТ-ийн эмч нарт томуугийн цаг үеийн байдал, статистик мэдээлллийн дүн шинжилгээний чиглэлээр сургалт зохион байгуулав.

Коронавирусын халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр Коронавирусийн тархалтын үед ажиллах төлөвлөгөөг батлан, шатахуун эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, 1 дүгээр сарын 26, 28-ны өдрүүдэд 26 сумын Эрүүл мэндийн төвтэй холбогдож, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээлэл авч, нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

### **Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:**

**Төсвийн орлогын талаар:** Орлогын төлөвлөгөө жилийн эцсийн дүнгээр орон нутаг 4514,6 сая төгрөг төвлөрүүлэхээс 6619,5 сая төгрөг төвлөрүүлж 146,6 хувьтай, 2104,9 сая төгрөгөөр буюу 46,6 хувиар давуулан биелүүллээ. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 16437,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 21534,6 сая төгрөг төвлөрүүлж 131.0 хувьтай, 5097,5 сая төгрөгөөр буюу 31,0 хувиар давуулан биелүүлсэн. Жилийн эцсийн байдлаар 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 7373,2 сая төгрөгөөр биелж, 125,8%-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн, Сүмбэр, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант зэрэг 17 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Аргалант, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Заамар, Цээл, Зуунмод зэрэг 9 сум, 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Архуст сум байна.

**Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:** Сумдад 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 81.722,8 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагад олгосон. Улсын төсвөөс Тусгай зориулалтын шилжүүлэгээр 41817,6 сая төгрөг, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг 6786,5, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4936,6 сая төгрөгийн санхүүжилт авсан.

**Салбараа авч үзвэл:** Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 32.555,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 22.290,5 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 10.265,1 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 8.504,1 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 8.245,8 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 258.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 528,0 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 229,9 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 39.905.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

- Сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгт 16064,8 сая төгрөг

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 11.180.1 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 10.438.6 сая төгрөг

-ОНХСангуудад 2.221.7 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

**Өр, авлагын талаар:** 2019 оны жилийн эцсийн байдлаар сумд болон төсөвт байгууллагууд нийт 182.091,8 мянган төгрөгийн авлага, 206.692,0 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 89,357.2 мянган төгрөг буюу 43,2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 34201,2 мянган төгрөг буюу 16,5 хувь нь цалингийн өглөг, 22312,2 мянган төгрөг буюу 10,8 хувь нь НДШ-ийн өр, 6840,7 мянган төгрөг буюу 3.3 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 19373,6 мянган төгрөг буюу 9.4 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 34607,1 мянган төгрөг буюу 16.8 хувийг бусад өр эзэлж байна.

### **Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд ХШҮ хийхэд 2019 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын хууль-2, УИХ-ын тогтоол-3, УИХ-ын байнгын хорооны тогтоол-5, Ерөнхийлөгчийн зарлиг-2, ЗГ-ын тогтоол-133, Ерөнхий сайдын захирамж-5, ЗГын хуралдааны тэмдэглэл-33, Засгийн газрын албан даалгавар-8 нийт 191 заалтын хэрэгжилт 96.9%-тай дүгнэгдэж ЗГХЭГ-т хүргүүлэв. Үүнээс 100%-169, 70%-17, 30%-1, Хугацаа болоогүй/үнэлэх боломжгүй - 4 заалт байна.

Сумдын 2019 оны жилийн эцсийн дүнгээр 27 сумын дундаж 86.64 хувьтай дүгнэгдсэнээс 6 сум А , 21 сум В үнэлгээтэй байна. 2018 оны жилийн эцсийн дүнгээс сумдын дундаж 0,94 пунктээр ахиж А үнэлгээтэй сум 5-аар өссөн. 2019 оны үйл ажиллагааны үр дүнгээр Тэргүүн байрыг Алтанбулаг сум–92.71, Дэд байрыг Баянцогт сум –91.64, Гутгаар байрыг Зуунмод сум–90.62, Дөтгөөр байрыг Дэлгэрхаан сум–90.49, Тавдугаар байрыг Борнуур сум–90.48, Тусгай байрыг Эрдэнэ- 90.47, Цээл-90.00 хувьтай эзэлсэн.

МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамааралтай 5 салбарын 94 арга хэмжээний хэрэгжилтийг тооцон аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 94.07 хувьтай дүгнүүлж, ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэлээ.



Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 97 зорилт 287 арга хэмжээний хэрэгжилт 93.57 хувьтай гарсан бөгөөд аймгийн ИТХ-д өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр 30 албан хаагчдад сургалт хийлээ. Мөн Дархан-Уул аймгийн ЗДТГ, Дархан-Уул аймгийн Орхон сумын ЗДТГ-т ISO олон улсын стандарт нэвтрүүлсэн туршлагыг судлав.

Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2020 оны “Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” урианы жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг дарга агентлаг, байгууллагын дарга нарын 2020 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г баталлаа.

**Санхүүгийн хяналтын чиглэлээр:** 2020 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 16,539.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 11,895.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 4,138.1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн акт, албан шаардлагын биелэлт гаргах хугацаа болоогүй байна.

### **Найм. Цэргийн штабын хүрээнд:**

2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын даргаар; сургалтын нэгдсэн төлөвлөгөөг Батлан хамгаалах яамны Төрийн бичгийн даргаар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Цэргийн бүртгэл явуулах тухай 2019 оны А/623 дугаар захирамжийг үндэслэн цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг сум, багт 2020 оны 01 дүгээр сарын 01-25-ны өдрүүдэд, Цэргийн штабт 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 2 дугаар сарын 04-ний өдөр хүртлэх хугацаанд хийж байгаа бөгөөд ажлын явц 80 хувьтай байна. Цэргийн бүртгэл хэрхэн явуулж байгаа талаар Зуунмод сумын 6 багт ажиллаж, газар дээр нь зааварчилгаа өгөв.